

БАТЛАВ

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.АЛТАНЦЭЦЭГ

**“ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЭМНЭЛГИЙН
МЭРГЭЖИЛТНИЙ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ”
СЭДЭВТ СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага болон олон улсын судалгааны дүнгээс үзэхэд, эмтэй холбоотой хор уршиг нь 30 хүн тутмын 1-д тохиолддог бөгөөд урьдчилан сэргийлэх боломжтой хор уршигийн тал хувь нь эмийн хэрэглээтэй холбоотой байна. Түүнчлэн эмийн гаж нөлөөний тохиолдлын ойролцоогоор 50 хувь нь урьдчилан сэргийлэх боломжтой гэж үздэг.¹

Манай орны хүн амын дунд эмийн зохистой хэрэглээний мэдлэг дутмаг, эмийг дур мэдэн хэрэглэсний улмаас эрүүл мэнд, амь насаараа хохирох, эмэнд хордох, дасал үүсэх, эмийн гаж нөлөө илрэх зэрэг сөрөг тохиолдлууд илэрсээр байна.

Эмнэлгийн болон эм зүйн тусламж үйлчилгээг хамгийн ойр хүргэж ажилладаг эмнэлгийн мэргэжилтнүүдийн эмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, мэдээллийг тогтмол сайжруулах нь эмчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Иймээс Эм судлалын салбар зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 3 дугаар хурлаас гарсан шийдвэр (Хавсралт 1)-ийг хэрэгжүүлэх нь энэхүү сургалтыг хийх үндэслэл болсон.

ХОЁР. ЗОРИЛГО

Эмийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, хандлага, оролцоог дээшлүүлэх.

Уриа: ХАМТДАА ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАЯ!

ГУРАВ. БАЙРШИЛ, ХУГАЦАА: ЭЭХХЗГ-ын хурлын танхимд 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр 14-17 цагийн хооронд

ДӨРӨВ. ХАМРАХ ХҮРЭЭ: Эмнэлгийн мэргэжилтнүүд (эмч, сувилагч, эм зүйч), орон нутгийнхан цахимаар оролцох

ТАВ. ХҮРЭХ ҮР ДҮН: Эм судлалын салбар зөвлөлийн хурлын шийдвэр хэрэгжиж, эмнэлгийн мэргэжилтний эмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, хандлага сайжирсан байна

ZOOM ID: 648 612 7972

Нууц үг: 123456

ХЯНАСАН:

¹ https://www.who.int/news-room/fact-sheets/detail/patient-safety?utm_source=chatgpt.com

АБТГ-ЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Т.МӨНХТУУЛ

БОЛОВСРУУЛСАН:
АБТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Т.ТУНГАЛАГ

Сургалтын хөтөлбөр

Хаана: ЭЭХХЗГ зааланд

Хэзээ: 2026.06.10-ны өдөр 14 цагт

Зохион байгуулагч: ЭЭХХЗГ, Аюулгүй байдал, тандалтын газар

Хамтран зохион байгуулагч: Эм зүйн мэргэжлээр төгсөгчдийн холбоо

Цагийн хуваарь	Хичээлийн сэдэв	Илтгэгч
13:40-14:00	Бүртгэл	
14:00-14:10	Нээлт	ЭЭХХЗГ-ын Аюулгүй байдал, тандалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхтуул
14:10-14:25	Фармаковижиланс	ЭЭХХЗГ, Аюулгүй байдал, тандалтын газрын ахлах мэргэжилтэн Л.Дулмаа
14:25-14:40	"Фармаковижилансийн үйл ажиллагааг зохицуулах журам" А/128	ЭЭХХЗГ, Аюулгүй байдал, тандалтын газрын эмийн чанар, аюулгүй байдал, эмийн гаж нөлөөний бүртгэл мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Тунгалаг
Гаж нөлөөнөөс сэргийлэх, харшлын сорил тавих арга (Антибиотик, тодосгогчийн жишээгээр)		
14:40-15:20	Эмийн харшлын ангилал	АШУҮИС-ийн ЭЗС-ийн багш Ц.Номин-Эрдэнэ
	Антибиотикийн харшлын эрсдэл	
	Сорилын төрөл	
	Сорил үнэлэх	
	Харшлын сорил, эмийн гаж нөлөөний ялгаа	
	Беталактамт антибиотикийн харшил	
	Беталактамт бус антибиотикийн харшил <ul style="list-style-type: none">○ Аминоглюкозид○ Фторхинолин○ Ванкомицин	
	Түлхүүр санаа	
15:20-15:30	Ярилцлагын цаг	
15:30-15:40	Цайны цаг	
Фармаковижилансийн үндсэн түлхүүр ойлголтууд		
15:40-16:20	Хувийн хэвшилд фармаковижилансийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь	Эм зүйн мэргэжлээр төгсөгчдийн холбооны гүйцэтгэх захирал М.Мөнхзул
16:20-16:50	Ярилцлагын цаг	
16:50-17:00	Сургалтын хаалт	ЭЭХХЗГ, Аюулгүй байдал, тандалтын газрын ахлах мэргэжилтэн Л.Дулмаа